

АПУ ХК болон Түүний Охин Компаниуд

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

(Хараат бус аудиторын дүгнэлтийн хамт)

УЛААНБААТАР ХОТ
2023 он

Агуулга

Хуудас

Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын батламж мэдэгдэл	1
Хараат бус аудиторын дүгнэлт	2-6
Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Тайлан	7
Нэгтгэсэн Ашиг, Алдагдал ба Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан	8
Нэгтгэсэн Өмчийн Өөрчлөлтийн Тайлан	9
Нэгтгэсэн Мөнгөн Гүйлгээний Тайлан	10-11
Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн тодруулга	12-81

Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын батламж мэдэгдэл

Компанийн удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

АПУ ХК болон түүний охин компаниуд (“Групп” гэх)-ын нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн. Удирдлага нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлан нь группийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлсэн болохыг баталгаажуулах үүрэгтэй.

Удирдлага Группийн санхүүгийн тайланг тодруулга 2 ба 5-т дурдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах, санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөвөөр илэрхийлж чадах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж бэлтгэсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн удирдлага Группийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа залилан, шамшигдал, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгон, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийн, холбогдох бүх нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

Группийн удирдлагаас АПУ ХК болон түүний охин компаниудын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.



Ц.Эрдэнэбилэг
Гүйцэтгэх захирал

Г.Энхбилэг
Санхүү эрхэлсэн
захирал

Монгол Улс,
Улаанбаатар хот

2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр



СОЛИД ЮНИТИ АУДИТ ХХК
Улаанбаатар хот, 16050, Баянгол дүүрэг,
2-р хороо, Үндсэн хуулийн гудамж-24,
Рокмон бюлдинг, 10-р давхар 1003 тоот
Утас:976+9906 3227, 976+9909 1993
И мэйл:info@solidunity.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчид болон
Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

Дүгнэлт

Бид АПУ ХК болон түүний охин компаниуд (“Групп” гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол бүхий нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлан нь АПУ ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (цаашид “СТОУС-ын Стандартууд” гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат Бус Байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (цаашид “НБЁЗОУСЗ-ийн Ёс зүйн Дүрэм” гэх) болон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байж, НБЁЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Асуудлыг онцлон тэмдэглэх нь – харьцуулах мэдээлэл

Групп 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрсний дараах үеийн хэмжилтийг нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо өөрчлөлт оруулахаар сонгож, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн харьцуулагдах мэдээлэлд буцаан мөрдөн хэрэгжүүлэх тохируулга хийсэн тухай тайлбарласан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга 2 (6)-г бид онцолж байна. Иймд санхүүгийн тайлангийн харьцуулагдах мэдээллийг дахин тайлагнасан болно. Бид дүгнэлтээ уг асуудлаас үүдэлтэйгээр хязгаарлаагүй болно.

Харьцуулагдах мэдээлэлтэй холбоотой бусад асуудал

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх болон тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бид харьцуулагдах мэдээллийг дахин тайлагнахад ашигласан нэгтгэсэн тайлангийн тодруулга 2 (б) болон тодруулга 33-д тусгасан буцаан мөрдөх залруулгуудыг аудитласан. Бидний дүгнэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга 2 (б) болон тодруулга 33-д дурдсан буцаан мөрдөх залруулгууд нь зохистой бөгөөд зохих ёсоор хэрэгжсэн.

Аудитын гол асуудлууд

Тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн их ач холбогдолтой асуудлуудыг бид өөрсдийн мэргэжлийн үнэлэмжийг ашиглан аудитын гол асуудалд оруулсан. Бид нэгтгэсэн санхүүгийн тайлангийн дүгнэлтийн хэлбэрийг сонгохдоо эдгээр асуудалд анхаарсан ба эдгээр асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй.

Борлуулалтын орлогын хүлээн зөвшөөрөлт

Нэгтгэсэн санхүүгийн Тодруулга 16, мөн Тодруулга 5(о)-д тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгыг харна уу.

Гол онцлох зүйлс	Тэдгээрийг шийдвэрлэсэн аудитын арга хэмжээ
Аудитын Олон Улсын Стандартын дагуу орлого хүлээн зөвшөөрөлттэй холбоотой урьдчилан таамагласан залилангийн эрсдэл байдаг гэж үздэг. Удирдлага төлөвлөсөн үр дүндээ хүрэх зорилт, шахалт байх тул бид энэхүү эрсдэлийг орлого бий болох үед үүсэх боломжтой эрсдэл гэж тодорхойлсон.	Борлуулалтын орлогын хувьд гүйцэтгэсэн аудитын горимууд: <ul style="list-style-type: none">- Бид хуурамч санхүүгийн тайлагналтай холбоотой борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийн процесст эрсдэл үүсэхээс сэргийлсэн хяналтын үйл явцын загварчлал, түүний хэрэгжилтийг үнэлсэн.- Бид борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийн цаг хугацаа, бодитоор оршин байгаа эсэх, үнэн зөв эсэхийг хянаж буй хяналтуудад илүү анхаарлаа хандуулсан ба удирдлагын борлуулалт, борлуулалтын орлогын хүлээн зөвшөөрөлттэй холбоотой хэрэгжүүлж буй хяналтуудаас сонгон авч, эдгээр хяналтуудыг тестлэн шалгасан.- Бид Группийн хэрэгжүүлж буй борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрөх бодлого, ажил гүйлгээний хүргэлтийн нөхцөлийн талаар ойлголт авахын тулд удирдлагатай ярилцлага хийж, борлуулалтын гэрээг түүвэрлэн шалгасан ба Группийн борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийн цаг хугацааг нягтлан бодох бүртгэлийн стандартын шаардлагатай жишиж үнэлсэн.- Бид борлуулалтын орлогыг зохих тайлант хугацаанд нь борлуулалтын гэрээнд тусгасан нөхцөлийн дагуу бүртгэсэн эсэхийг жилийн эцэстэй ойр бүртгэсэн борлуулалтын ажил гүйлгээг түүвэрлэн сонгож, барааны зарлагын баримт эсвэл борлуулсан барааг хүргэж өгсөн үед харилцагч хүлээн авсныг баталгаажуулсан баримттай харьцуулж үнэлсэн.- Бид Группийн үндсэн орлогын шугамуудын чиг хандлагын шинжилгээг гүйцэтгэсэн ба борлуулалтын тоо хэмжээ болон үнийн мэдээллийг ашиглан Группийн борлуулалтын орлогын хүлээгдэж буй хэмжээг тодорхойлсон. Мөн Групп болон харилцагчдын борлуулалтыг баталгаажуулахаар харилцагчийн тулган баталгаажуулалт зэрэг аудитын горимуудыг гүйцэтгэсэн.- Бид орлого хүлээн зөвшөөрөх ердийн үйл явцаас гадуур борлуулалтын орлогын журналын бичилтүүд хийгдсэн эсэхийг шалгасан.- Бид нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудыг СТОУС 15-ын шаардлагын дагуу шинжилж үзсэн.
Дээрх хүчин зүйлстэй холбоотойгоор бид борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн гол онцлох зүйл гэж авч үзсэн.	

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт жилийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба нэгтгэсэн санхүүгийн тайлан болон бидний дүгнэлт хамрахгүй болно. Жилийн тайлан аудиторын тайлангийн өдрөөс хойш бэлэн болохоор хүлээгдэж байна.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Дээр дурдсан бусад мэдээллийг боломжтой болсон үед нь уншиж танилцан, уг мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад олж авсан бидний ойлголттой материаллаг хэмжээгээр нийцэхгүй эсвэл материалагаар буруу илэрхийлэгдсэн зүйлс байгаа эсэхийг шалгах нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний хүлээх үүрэг, хариуцлага юм. Бусад мэдээлэлтэй танилцаад материаллаг алдаа байна гэж үзвэл энэ талаар бид засаглах эрх бүхий этгээдүүдэд мэдэгдэх үүрэгтэй.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Нэгтгэсэн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид СТОУС гэх)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах үүрэг, хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайланг бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай дотоод хяналтыг тодорхойлох үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх группийн чадамжийг үнэлж, тодруулах, шаардлагатай бол группийг татан буулгахаар, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор, эсвэл ингэхээс өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Группийн санхүүгийн тайлагналын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг хариуцлага хүлээнэ.

Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Бидний зорилго нь нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан тайлан гаргах юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-н дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлж байна гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийгдээ нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Бид АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар мэргэжлийн шүүмж ашиглаж, аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг ба бид,

- Залилан эсвэл алдааны улмаас нэгтгэсэн санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, уг эрсдэлийг үнэлэн, эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг.

Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.

- Группийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Группийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүйд хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн ерөнхий тодруулга, бүтэц, агуулгыг үнэлж нэгтгэсэн санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.
- Нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд Группт хамаарах аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээллийн талаарх хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо олж авдаг. Бид группийн хэмжээний аудитыг удирдан чиглүүлж, хяналт тавьж, мөн гүйцэтгэх үүрэгтэй. Бид зөвхөн гаргасан дүгнэлтийнхээ хүрээнд хариуцлага хүлээнэ.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Мөн бид засагдах эрх бүхий этгээдүүдэд хараат бус байдлын талаарх холбогдох ёс зүйн шаардлагыг биелүүлсэн тухай мэдэгдэл хийдэг бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц бүхий л харилцаа болон бусад асуудал, зарим тохиолдолд түүний эсрэг үзүүлсэн хариу үйлдлийн талаар мэдэгдэл хийдэг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас бид тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдолтой гэж үзсэн зүйлсийг аудитын гол онцлох зүйлс хэмээн тодотгосон болно. Бид аудитын гол онцлох зүйлсийг хууль тогтоомжоор нийгэд ил болгохыг хориглоогүй үед эсвэл маш ховор тохиолдолд тайланд тодруулахгүй байх нь тодруулснаас илүүтэйгээр нийтийн эрх ашигт нийцнэ гэж үзсэнээс уг онцлох зүйлсийг тайланд оруулахгүй хэмээн шийдвэр гарснаас бусад тохиолдолд эдгээр зүйлсийг тайландаа оруулдаг.

Бусад асуудлууд

Энэхүү тайлан нь Зөвхөн группийн гишүүдэд зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.



Солид Юнити Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот, 16050,
Баянгол дүүрэг, 2-р хороо,
Үндсэн Хуулийн гудамж-24,
Рокмон бюлдинг, 1003 тоот

2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг нэгтгэсэн санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна уу

АПУ ХК болон Түүний Охин Компаниуд
Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<i>Тод- руулга</i>	2022.12.31	2021.12.31 (Дахин тайлагнасан)	2020.12.31 (Дахин тайлагнасан)
Хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	6	415,600,484	282,877,745	261,897,450
Биет бус хөрөнгө ба гүүдвил	7	74,044,933	80,976,992	87,305,933
Хойшлогдсон татварын хөрөнгө	23	1,336,981	1,033,880	1,252,348
Эргэлтийн бус хөрөнгө		490,982,398	364,888,617	350,455,731
Бараа материал	8	185,883,448	87,714,055	83,348,435
Урьдчилгаа, урьдчилж төлсөн зардал	9	65,529,920	53,774,157	17,664,409
Орлогын татварын авлага	23	9,656,075	148,258	-
Дансны болон бусад авлага	10, 26	51,008,440	32,722,572	39,013,069
Бусад санхүүгийн хөрөнгө оруулалт	26	-	-	500,000
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	11, 26	38,365,107	77,277,711	64,059,208
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		709,036	-	-
Эргэлтийн хөрөнгө		351,152,026	251,636,753	204,585,121
Нийт хөрөнгө		842,134,424	616,525,370	555,040,852
Эздийн өмч				
Хувьцаат капитал	12	106,297	106,297	106,297
Нэмж төлөгдсөн капитал	12	338,094,870	338,094,870	338,094,870
Нэгдлийн нөөц	12	(112,795,804)	(112,795,804)	(112,795,804)
Дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц	6, 12	156,566,882	92,842,146	93,141,856
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		703,518	(43,443)	(21,285)
Хуримтлагдсан ашиг		220,738,413	186,011,795	136,350,775
Группийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах өмч		603,414,176	504,215,861	454,876,709
Хяналтын эрхгүй цөөнхийн хувь оролцоо	27	30,163,068	83,821	6,116,626
Нийт эздийн өмч		633,577,244	504,299,682	460,993,335
Өр төлбөр				
Хойшлогдсон татварын өглөг	23	25,539,734	15,978,196	18,088,647
Бусад урт хугацаат өр төлбөр	14, 26	2,325,831	-	-
Урт хугацаат түрээсийн өглөг	24	31,333,809	13,134,413	7,764,189
Ажилтны тэтгэмж	13	1,380,674	816,774	656,483
Урт хугацаат зээл	15, 26	18,333,200	21,115,448	2,000,000
Урт хугацаат өр төлбөр		78,913,248	51,044,831	28,509,319
Богино хугацаат түрээсийн өглөг	24	10,935,008	5,266,417	2,318,607
Орлогын татварын өглөг	23	191,148	8,145,789	2,698,028
Дансны өглөг	14, 26	51,632,914	21,964,976	11,365,371
Бусад өглөг	14, 26	61,718,062	25,803,675	49,156,192
Богино хугацаат зээл	15, 26	5,166,800	-	-
Богино хугацаат өр төлбөр		129,643,932	61,180,857	65,538,198
Нийт өр төлбөр		208,557,180	112,225,688	94,047,517
Нийт өр төлбөр ба эздийн өмч		842,134,424	616,525,370	555,040,852

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн саллигүй хэсэг болно.

АПУ ХК болон Түүний Охин Компаниуд
Нэгтгэсэн Ашиг Алдагдал ба Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<i>Тод- руулга</i>	2022	2021 (Дахин тайлагнасан)
Борлуулалтын орлого	16	850,239,813	678,164,129
Борлуулалтын өртөг	17	(478,212,778)	(343,229,879)
Нийт ашиг		372,027,035	334,934,250
Борлуулалт, удирдлагын зардал	18	(201,931,899)	(138,347,844)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэний бууралт	10, 11	111,674	(301,951)
Бусад орлого	19	7,656,079	3,760,573
Бусад зардал	20	(13,410,462)	(2,216,848)
Үйл ажиллагааны ашиг		164,452,427	197,828,180
Санхүүгийн орлого	21	151,237	520,070
Санхүүгийн зардал	22	(10,491,453)	(3,653,295)
Татварын өмнөх ашиг		154,112,211	194,694,955
Орлогын албан татварын зардал	23	(28,214,649)	(41,073,744)
Тайлант үеийн цэвэр ашиг		125,897,562	153,621,211
Бусад дэлгэрэнгүй орлого:			
<i>Ашиг, алдагдал руу дахин ангилагдахгүй зүйлс:</i>			
Дахин үнэлгээний нэмэгдэл		65,809,809	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		746,961	(22,158)
Ажилчдын тэтгэмжийн дахин хэмжилтийн алдагдал		(438,863)	(274,819)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого		192,015,469	153,324,234
Ашиг/(алдагдал):			
Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ноогдох		144,692,756	159,654,016
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ноогдох		(18,795,194)	(6,032,805)
Тайлант үеийн цэвэр ашиг		125,897,562	153,621,211
Бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал):			
Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ноогдох		210,810,663	159,357,039
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ноогдох		(18,795,194)	(6,032,805)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлогын нийт дүн		192,015,469	153,324,234
Нэгж хувьцаанд ногдох ашиг			
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг	32	136.1	150.2

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

АПУ ХК болон Түүний Охин Компаниуд
Нэгтгэсэн Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

	Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд							Хяналтын эрхгүй хувь оролцоо (Тод 27)	Нийт өмчийн дүн
	Хувьцаат капитал (Тод 12)	Нэмж төлөгдсөн капитал (Тод 12)	Нэгдлийн нөөц (Тод 12)	Дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц (Тод 6,12)	Гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт		
<i>(Мянган төгрөгөөр)</i>									
2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	106,297	338,094,870	(112,795,804)	100,177,551	(21,285)	129,937,425	455,499,054	6,116,626	461,615,680
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга (Тод 2, Тод 33)	-	-	-	(7,035,695)	-	6,413,350	(622,345)	-	(622,345)
2021 оны 01-р сарын 01-нээрх залруулсан үлдэгдэл	106,297	338,094,870	(112,795,804)	93,141,856	(21,285)	136,350,775	454,876,709	6,116,626	460,993,335
<i>Нийт дэлгэрэнгүй орлого:</i>									
Тайлант үеийн цэвэр ашиг (дахин тайлагнасан)	-	-	-	-	-	159,654,016	159,654,016	(6,032,805)	153,621,211
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	(22,158)	(274,819)	(296,977)	-	(296,977)
Зарласан ноогдол ашиг	-	-	-	-	-	(110,017,887)	(110,017,887)	-	(110,017,887)
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн	-	-	-	(299,710)	-	299,710	-	-	-
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл (Дахин тайлагнасан)	106,297	338,094,870	(112,795,804)	92,842,146	(43,443)	186,011,795	504,215,861	83,821	504,299,682
2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	106,297	338,094,870	(112,795,804)	92,842,146	(43,443)	186,011,795	504,215,861	83,821	504,299,682
<i>Нийт дэлгэрэнгүй орлого:</i>									
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	-	-	144,692,756	144,692,756	(18,795,194)	125,897,562
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	65,809,809	746,961	(438,863)	66,117,907	-	66,117,907
Зарласан ноогдол ашиг	-	-	-	-	-	(111,612,348)	(111,612,348)	-	(111,612,348)
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	48,874,441	48,874,441
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн	-	-	-	(2,085,073)	-	2,085,073	-	-	-
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	106,297	338,094,870	(112,795,804)	156,566,882	703,518	220,738,413	603,414,176	30,163,068	633,577,244

АПУ ХК болон Түүний Охин Компаниуд
Нэгтгэсэн Мөнгөн Гүйлгээний Тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<i>Тод- руулга</i>	2022	2021 (Дахин тайлагнасан*)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант жилийн ашиг		125,897,562	153,621,211
Тохируулга:			
Орлогын албан татварын зардал	23	28,214,649	41,073,744
Түрээсийн хүүгийн зардал	22	4,728,702	2,092,308
Зээлийн хүүгийн зардал	22	1,917,134	802,001
Нөөцийн дискаунтын чөлөөлөлт	22	56,002	43,973
Хүүгийн орлого	21	(151,237)	(520,070)
Валютын ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй гарз/(олз), цэвэр		6,222,387	(153,951)
Элэгдлийн зардал	6	59,293,818	36,021,899
Хорогдуулгын зардал	7	7,466,003	7,381,218
Дансны болон бусад авлагын үнэ цэний бууралт, (цэвэр)	10	48,127	262,394
Банкны үлдэгдэл дэх үнэ цэний бууралт	11	(159,801)	39,557
Бараа материалын үнэ цэний бууралт	8	21,948	179,632
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	19	(127,793)	(101,639)
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	20	29,474	448,784
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз (олз)	20	588,678	374,964
Дахин үнэлгээний нэмэгдлийн гарз (олз)	19, 20	8,358,289	-
		242,403,942	241,566,025
Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт::			
Дансны авлага болон бусад авлага		(17,466,618)	6,027,757
Бараа материал		(97,861,588)	(4,560,480)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		(709,036)	-
Урьдчилгаа, урьдчилж төлсөн зардал		(13,209,846)	(16,134,276)
Дансны өглөг		25,559,708	10,728,276
Бусад өглөг		25,273,304	(15,864,158)
Ажилтны тэтгэмж		69,035	(158,501)
		164,058,901	221,604,643
Зээлийн хүүний төлбөрт төлсөн		(579,223)	(802,001)
Түрээсийн хүүний төлбөрт төлсөн	24	(4,728,702)	(2,092,308)
Хүлээн авсан хүүгийн орлого		151,237	520,070
Төлсөн орлогын албан татвар		(46,256,577)	(37,666,608)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		112,645,636	181,563,796

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.